



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 04

Даланзадгад

Өмнөговь аймгийн 90 жилийн ойг угтаж
90000 ширхэг мод тарьж ургуулах арга
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 88 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/186 дугаар захирамжийг тус тус үндэслэн, Өмнөговь аймгийн хэмжээнд 90000 ширхэг мод тарих арга хэмжээг 5, 10 дугаар саруудад олон нийтийг хамруулан өргөн хүрээтэй зохион байгуулж, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг хангах, мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор ДААЛГАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

1.1 Бүх нийтээр мод тарьж, ургуулах үндэсний өдрийн нээлтийн арга хэмжээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулах.

1.2 Аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг угтаж аймгийн хэмжээнд 90000 ширхэг мод тарьж ургуулах зорилгоор айл, өрх 9 ширхэг, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага 90 ширхэг, уул уурхайн компани тус бүр 900 ширхэг мод тарьж ургуулах арга хэмжээг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах.

1.3 Даланзадгад суманд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлж, 90 жилийн ойд зориулсан цэцэрлэгт хүрээлэн байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн судалгааг нэгтгэж шийдвэрлүүлэх.

1.4 Ашигт ургамал болон жимсний модны суулгацыг айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг мод үржүүлгийн газруудтай хамтран зохион байгуулах.

2. Сумын Засаг дарга нарт:

2.1 Сумын хэмжээнд байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, уул уурхайн компаниуд, иргэдийг мод тарих, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд татан оролцуулж, тарьц, суулгацаар хангах, мод тарьж ургуулах арчилж, хамгаалах арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудад хариуцуулан өгч, үйл ажиллагаанд нь байнгын хяналт тавьж ажиллах.

462210007

2.

2.2 Сумын ард иргэд, хүүхэд залуучуудад мод тарих, ойжуулах ажлын мэдлэг олгох, байгаль хамгаалах уламжлалт арга, цөлжилт, байгаль орчны доройтлын сөрөг үр дагаврын талаар цахим сургалт зохион байгуулж, мод тарих, услах, арчлах ажилд татан оролцуулах.

2.3 Таримал ойн зурвас байгуулах эрх шилжүүлж гүйцэтгүүлсэн нэр бүхий сумд 2017-2018 онд эхлүүлсэн ойжуулалтын талбайн тариалалтын ажлыг бүрэн хийлгэж хүлээн авах, арчилгаа хамгаалалтыг хариуцан ажиллах. (Баяндалай, Ноён, Сэврэй, Мандал-Овоо, Цогт-Овоо Булган, Номгон, Хүрмэн, Гурвантэс, Ханхонгор)

2.4 Тус онд таримал ойн зурвас байгуулагдах Цогт-Овоо, Манлай, Ханбогд, Баян-Овоо сумд бэлтгэл хангаж, гүйцэтгэгчийн ажлын явц, гүйцэтгэлд байнгын хяналт хийж ажиллан, гэрээт хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, байгуулагдсан ойн зурвасыг эзэнжүүлэх, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллах.

2.5 Ногоон байгууламж, булаг шандны эхэнд хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, суваг шуудууг сэргээх, суулгацны нүх ухах, хашаа, хайс барих, засварлах зэрэг мод тарих бэлтгэлийг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулах.

2.6 Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай байгуулагдсан нэр бүхий сумд тус талбайд мод тарьж ургуулах, зүлэгжүүлэх ажлыг бүрэн гүйцэтгүүлж, эзэнжүүлэх, арчилгаа хамгаалалтыг сайжруулах. (Баяндалай, Баян-Овоо, Булган, Цогт-Овоо, Мандал-Овоо, Манлай, Номгон)

2.6 Заган ой бүхий сумд байгалийн сэргэн ургалтад туслах, нөхөн сэргээх, заган ойг нэмэгдүүлэх арга хэмжээг байгаль хамгаалах чиглэлийн төрийн бус байгууллага, уул уурхайн компаниудтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

2.7 Газрын тухай хуулийн 56.6 дахь заалт *Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана/-ын хэрэгжилтийг хангуулж ажиллах.*

2.8 Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журмыг хэрэгжүүлж, сумдын салбар комисс иргэдэд сургалт сурталчилгаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх.

2.9 Ашигт ургамал болон жимсний модны суулгацыг айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр олгох арга хэмжээг зохион байгуулж, тарьж ургуулах, үржүүлэхэд байнгын хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллах.

2.10 Төв суурингийн дотор болон гаднах автозам бүхий сумд зам дагуу мод тарих ажлыг холбогдох стандартын дагуу тарьж, арчилж хамгаалах

2.11 Төв суурингийн бүсийг тогтоож, тухайн бүсэд мал сүрэг оруулах, ногоон байгууламж сүйтгэх, хог бутраах, бэлчээрлэх байдлыг бүрэн зогсоох арга хэмжээ авах.

2.12 Аймгийн хэмжээнд 90,000 ширхэг мод тарих нэгдсэн арга хэмжээг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүрэн оролцуулж ажиллах.

2.13 Бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулахад Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллыг бүрэн хангаж ажиллах.

3. Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн ангид:

3.1 Мод тарьж ургуулах, зүлэгжүүлэх, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтын талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийтэд сургалт, мэдээллийг хүргэж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.

3.2 Айл, өрх 9 ширхэг, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага 90 ширхэг, уул уурхайн компани тус бүр 900 ширхэг мод тарихад шаардагдах тарьц, суулгацын судалгаа, тоо хэмжээг гарган, 15 суманд хуваарилалтыг хийж, татан авалт, тарилтад хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, суулгацыг тарьж, ургуулахад анхаарч, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар бүх сумтай хамтран ажиллах.

3.3 Ашигт ургамал болон жимсний модны суулгацыг айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр олгох, тарьж ургуулах, үржүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтийг нэгтгэж тайлагнах.

3.4 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдад таримал ойн зурвас, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай байгуулахаар урьд жилүүдэд хийгдсэн болон гүйцэтгэл дутуу мөн шинээр хийгдэх ногоон байгууламжийн ажлын явц, гүйцэтгэлд байнгын хяналт тавин, биелэлтийг хангуулах, сумдын удирдлага, холбогдох мэргэжилтэнг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах.

3.5 Даланзадгад суманд “90 жилийн ойн цэцэрлэгт хүрээлэн” байгуулах болон 80 га талбайг хашаажуулж, нөхөн тарилт хийх ажлыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэх.

3.6 Гурвантэс, Ноён, Сэврэй, Баяндалай сумдын заган ойн байгалийн сэргэн ургалтад туслах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлд байнгын хяналт хийж, хамтран ажиллах.

3.7 “Ногоон паспорт-Ногоон төгөл”-ийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх.

3.8 Ногоон хэрэм төслөөс хүлээн авсан талбайг мэргэжлийн байгууллагуудад гэрээгээр эзэмшүүлэх, арчилгаа, хамгаалалтыг гүйцэтгүүлэх.

4. Нийт албан байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, уул уурхайн компани, төрийн бус байгууллагуудад:

4.1 Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага 90 ширхэг, уул уурхайн компани тус бүр 900 ширхэг модны тарьц суулгацаа бэлтгэж, байгууллагын гадна талбайд болон, сумаас хуваарилсан талбайд тарьж ургуулах, цаашид арчлан

4.

хамгаалах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэх. /Мэргэжлийн байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу шаардлага хангасан нэр, төрлийн мод авч тарих/

4.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Тонн баялаг-Нэг мод” хөтөлбөр, 2018 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Нэрэмжит болгох тухай” тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

4.3 Уул уурхайн компаниуд орон нутагтай хамтран ажиллах хамтын ажиллагааны гэрээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээг харьяалагдах сумдтай хамтран хэрэгжүүлэх.

5.Хяналт

5.1 Сум, агентлаг, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нар албан даалгаврын хэрэгжилтийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 6,12 сарын 20-ны дотор, Байгаль орчин, аялал жуулчлалын газар нэгтгэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 6,12 сарын 25-ны дотор тус тус ирүүлэх.

5.2 Албан даалгаврын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж холбогдох байгууллагуудад тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (О.Эрдэнэ-Өрнөх)-т, хэрэгжилт үр дүнд хяналт хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Б.Уянга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Р.СЭДДОРЖ